



Монголын багш нарын 53 дахь өдрийг тохиолдуулан Орхон аймгийн их, дээд сургууль, МСҮТ-ийн дунд зохион байгуулж буй “БАГШ-ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ”-ын удирдамж

**Хэзээ:** 2019 оны 10 дүгээр сарын 03, Пүрэв гариг, 14:00 цаг

**Зохион байгуулагч:** МУИС-ийн Эрдэнэт сургууль

**Хурлын зорилго:** Багш нарын судалгаа шинжилгээний ажил хийх идэвхийг нэмэгдүүлж тогтмолжуулах, багш судлаач, эрдэмтэд шинжилгээ судалгааны ажлын үр дүнгээ танилцуулах, санал бодлоо солилцох, харилцан шинэ мэдлэг түгээх, туршлага солилцох

**Илтгэлийн агуулга: Боловсрол судлал**

- Заах арга зүй
- Гадаад хэл судлал
- Сэтгэл судлал
- Түүх, соёл судлал
- Мэдээллийн технологи

**Бүртгэлийн хугацаа:** Илтгэлийг цаасан болон электрон хэлбэрээр 2019 оны 09 сарын 16 өдрөөс 09 сарын 27-ны өдрийг дуустал дараах цахим хаягаар хүлээн авна. Email: [erdenet.num@gmail.com](mailto:erdenet.num@gmail.com)

Илтгэлийг бүрэн эхээр (full text) нь хүлээн авах хугацаа: **2019 оны 09 сарын 27**

Илтгэлийн товч танилцуулга (presentation) хүлээн авах хугацаа: **2019 оны 10 сарын 01**

**Илтгэлийн эхэд тавигдах шаардлага:**

1. Илтгэлийг MSW программаар Times New Roman, Batang, SimSun, MS Mincho фондоор бичих
2. Хуудсын хэмжээ А4, үсгийн өндөр 12 pt, мөр хоорондын зай /Single/, бичвэрийн хоёр талыг тэгшлэх /Justify/
3. Илтгэл 4-8 нүүр байх
4. Хамтарсан илтгэл 2 зохиогчоос илүүгүй байх
5. Хуралд хэлэлцэх илтгэл нь цаасан хэлбэртэй байх /2-3 хувь бэлтгэж ирэх/
6. Илтгэгчийн нэр, эрдмийн зэрэг цол, ажлын газар, цахим хаягийг тодорхой бичих
7. Түлхүүр үг: 5-аас доошгүй байх

**Илтгэлийн бүтэц:**

1. Гарчиг, зохиогчийн нэр
2. Түлхүүр үг
3. Зорилго, зорилт
4. Судалгааны арга, аргачлал
5. Судалгааны үндсэн хэсэг
6. Дүгнэлт
7. Ном зүй /APA стандарт/

**Хурлын дэг:**

1. Илтгэх хугацаа 8 мин
2. 3 илтгэлийн дараа асуулт хариулт явагдана.
3. Асуулт хариулт (нэг илтгэлд 3-4 мин)

**Байр:**

- 1-р байр – Өргөмжлөл, дурсгалын зүйл
  - 2-р байр – Өргөмжлөл, дурсгалын зүйл
  - 3-р байр – Өргөмжлөл, дурсгалын зүйл
- Нийт оролцогчдад Батламж гардуулах

**Бусад.**

- ❖ 1 сургуулиас 1 шүүгч багшийн нэр ирүүлэх
- ❖ 1 сургуулиас шилдэг 2 илтгэл ирүүлэх

**Холбоо барих утасны дугаар:** 99365624, 70350901